



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН МАТЕРИАЛ**

2026 оны 9-р сарын 25-ны өдөр

# АГУУЛГА

|                                                                                              |    |
|----------------------------------------------------------------------------------------------|----|
| • Хурлын зар .....                                                                           | 3  |
| • Хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын тогтоол.....                                 | 4  |
| • Хувьцаа эзэмшигчдийн танилцах боломжтой баримт бичгийн жагсаалт, хугацаа, арга хэлбэр..... | 6  |
| • Хурлын хөтөлбөр .....                                                                      | 7  |
| • Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой материал                                           |    |
| 1. Компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр үргэлжлүүлэх тухай .....                  | 8  |
| 2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга .....                                         | 10 |
| • Хурлаас гарах тогтоолын төсөл .....                                                        | 16 |
| • Хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн .....                                                | 18 |
| • Санал авах хуудасны загвар .....                                                           | 19 |
| • Цахим хэлбэрээр хуралд оролцох заавар .....                                                | 23 |



## ХУРЛЫН ЗАР

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2026 оны 8-р сарын 14-ний өдрийн №27 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ыг зарлаж байгаа тул хувьцаа эзэмшигч та бүхнийг оролцохыг урьж байна.

**Хурлын өдөр:**

**2026 оны 9-р сарын 25-ны өдөр, Баасан гараг**

**Эхлэх цаг:**

**10:00 цаг**

**Хурал зохион байгуулах хэлбэр:**

AGM систем (www.agm.mn)-ийг ашиглан **цахим хэлбэрээр**

**Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:**

2026 оны 9-р сарын 4-ний өдөр

**Хурлаар хэлэлцэх асуудал:**

1. Компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр үргэлжлүүлэх тухай хэлэлцэн батлах;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.

**Хурлын материалтай танилцах:**

Хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь **2026 оны 8-р сарын 24-ний өдрөөс эхлэн** дараах арга хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцаж болно. Үүнд:

- Өөрийн харилцдаг үнэт цаасны компани эсвэл хурлын тооллогын комиссоор ажиллаж буй БиДиСек ҮЦК ХХК (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, Утас: 7555-1919)-аас цахимаар болон биечлэн очиж;
- Говь ХК-ийн цахим хуудас (info.gobi.mn);
- Говь ХК-ийн оффисын төв байрны (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК) 4-р давхарт ажлын өдрүүдийн 09:00-17:00 цагийн хооронд ирж танилцах боломжтой.

**Урьдчилан санал өгөх:**

Хурлын материалтай танилцан, саналын хуудсыг бөглөж дараах арга хэлбэрээр **2026 оны 9-р сарын 22-ны өдрийн 17:00 цаг хүртэл** иргэний үнэмлэх (хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ)-ний хуулбарын хамт ирүүлнэ үү:

- Өөрийн харилцдаг үнэт цаасны компани эсвэл хурлын тооллогын комиссоор ажиллаж буй БиДиСек ҮЦК ХХК (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, Утас: 7555-1919)-аар дамжуулан өгөх;
- Говь ХК-ийн оффисын төв байранд биечлэн ирж өгөх, эсвэл шуудангаар илгээх (Говь ХК-ийн албан ёсны хаяг);
- Цахимаар ирүүлэх (boardsecretary@gobicashmere.com).

**Хурал зохион байгуулах комисстой холбоо барих:**

Утас: 9411-8277  
И-мэйл: boardsecretary@gobicashmere.com

**Говь ХК-ийн албан ёсны хаяг:**

Улаанбаатар - 17062, ХУД, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК  
Утас: 7013-9977, Факс: 7014-3081, Шуудангийн хайрцаг: 36/434, Говь ХК



# ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 он 08 сар 14 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

## **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай**

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ыг зарлан хуралдуулах асуудлыг хэлэлцэн, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.1, 60.2, 60.4, 61.1.5, 64.2, 65, 67, 71.1, 71.3, 76.1.2, 80.2 дугаар зүйл заалт, Компанийн дүрмийн 6.1.2, 6.1.4, 6.1.7.5, 6.2.7.3, 6.2.7.4, 6.2.8 дугаар зүйл заалтуудыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

### **1. Хурлын тов**

- 1.1. Хурлыг **2026 оны 9-р сарын 25-ны Баасан гарагийн 10:00 цагт** AGM систем ([www.agm.mn](http://www.agm.mn))-ийг ашиглан **цахим хэлбэрээр** хуралдуулсугай.

### **2. Хэлэлцэх асуудал, санал хураах журам**

- 2.1. Хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтыг **Хавсралт 1-ээр** баталсугай.
- 2.2. Хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцах боломжтой баримт бичгийн жагсаалт, хугацаа, арга хэлбэрийг **Хавсралт 2-оор** баталсугай.
- 2.3. Санал авах хуудасны загварыг **Хавсралт 3-аар** баталсугай.
- 2.4. Хувьцаа эзэмшигчдийн саналыг хурлын үеэр цахим хэлбэрээр авахаас гадна урьдчилсан байдлаар **2026 оны 9-р сарын 22-ны өдрийн 17:00 цаг хүртэл** хугацаанд үнэт цаасны компаниар дамжуулан эсхүл компанийн оффисын төв байр, шуудангийн хаяг, цахим хаягаар цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авах боломжийг бүрдүүлэн ажиллахыг Хурал зохион байгуулах комиссын даргад үүрэг болгосугай.

### **3. Бүртгэл, мэдээлэл хүргүүлэх**

- 3.1. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2026 оны 9-р сарын 4-ний өдрөөр** тогтоосугай.
- 3.2. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид **2026 оны 8-р сарын 17-ны өдөр** хүргүүлж, хурлын зарыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу **2026 оны 8-р сарын 19 болон 9-р сарын 3-ны өдрүүдэд** олон нийтэд зарлахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (М.Сэлэнгэ)-д үүрэг болгосугай.
- 3.3. Хурлын зарын хэвлэлийн эхийг **Хавсралт 4-өөр** баталсугай.

### **4. Хурлын баримт бичиг**

- 4.1. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг **2026 оны 8-р сарын 24-ний өдрийн дотор** үнэт цаасны компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (М.Сэлэнгэ)-д үүрэг болгосугай.

“Говь” ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17062, Монгол улс  
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, И-мэйл: [info@gobi.mn](mailto:info@gobi.mn), Вэб сайт: [www.gobi.mn](http://www.gobi.mn)

**5. Хурлын зохион байгуулалт**

- 5.1. Хурлыг ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал **Б.Амарсайхан** даргалсугай.
- 5.2. Хурлын хөтөлбөрийг **Хавсралт 5**-аар баталсугай.
- 5.3. Хурал зохион байгуулах комиссыг **Хавсралт 6**-аар томилсугай.
- 5.4. Хурлын Тооллогын комиссыг **Хавсралт 7**-оор томилсугай.
- 5.5. Хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахад шаардлагатай мэдээлэл технологийн цахим шийдлийг бүрдүүлж бэлтгэлийг хангах, хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичиг, мэдээллийг бэлдэх, хөтөлбөрийн дагуу зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комиссын даргад үүрэг болгосугай.
- 5.6. Хурлын ирцийг бүртгэж Хурлын даргад мэдээлэх, хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсыг цаасан болон цахим хэлбэрээр авч, тооллогын үр дүнг нэгтгэн Хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Тооллогын комиссын даргад үүрэг болгосугай.

**6. Хурлын шийдвэрийн хэрэгжилт**

- 6.1. Хурлын шийдвэр болон бусад холбогдох баримт бичиг, тайлан мэдээллийг холбогдох хууль журамд заасан хугацаанд олон нийтэд мэдээлж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (М.Сэлэнгэ)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ийн дарга  Ц.БААТАРСАЙХАН







## ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БОЛОМЖТОЙ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ, ХУГАЦАА, АРГА ХЭЛБЭР

1. Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
  - Хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол;
  - Хурлын зар, хурлын хөтөлбөр;
  - Компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр үргэлжлүүлэхтэй холбоотой мэдээлэл;
  - ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;
  - Хурлаас гарах тогтоолын төсөл;
  - Хурлын санал авах хуудас;
  - Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой бусад мэдээлэл.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2026 оны 8-р сарын 24-ний өдрөөс эхлэн дараах арга хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
  - Өөрийн харилцдаг үнэт цаасны компани эсвэл хурлын тооллогын комиссоор ажиллаж буй БиДиСек ҮЦК ХХК (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, Утас: 7555-1919)-аас цахимаар болон биечлэн очиж;
  - Говь ХК-ийн цахим хуудас ([info.gobi.mn](mailto:info.gobi.mn));
  - Говь ХК-ийн оффисын төв байрны (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК) 4-р давхарт ажлын өдрүүдийн 09:00-17:00 цагийн хооронд ирж танилцах боломжтой.

## ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

|                                                                                                                                                                |             |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|
| Хурлын хөтөлбөрийг танилцуулах<br><i>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ</i>                                                                                | 10:00-10:02 |
| Хурлын ирцийг танилцуулах<br><i>Тооллогын комиссын дарга Б.Онон</i>                                                                                            | 10:02-10:05 |
| Хурлыг нээх<br><i>Хурлын дарга Б.Амарсайхан</i>                                                                                                                | 10:05-10:07 |
| Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина:                                                                                              |             |
| 1. Компанийн хэлбэрийг нээлттэй хувьцаат компани хэвээр үргэлжлүүлэх тухай танилцуулах<br><i>Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан</i>                                | 10:07-10:20 |
| 2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах<br><i>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ</i>                                                                | 10:20-10:30 |
| Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт<br><i>20 минут</i>                                                                                           | 10:30-10:50 |
| Санал өгөх зааварчилгаа танилцуулах<br><i>Тооллогын комиссын дарга Б.Онон</i>                                                                                  | 10:50-10:52 |
| Санал хураах<br><i>8 минут</i>                                                                                                                                 | 10:52-11:00 |
| Завсарлага /Санал хураалтын дүнг нэгтгэх/<br><i>15 минут</i>                                                                                                   | 11:00-11:15 |
| Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах<br><i>Тооллогын комиссын дарга Б.Онон</i>                                              | 11:15-11:20 |
| Хурлаас гарах тогтоолын төсөлд Тооллогын комиссын санал хураалтын дүнг тусган танилцуулж, тогтоолыг батлуулах<br><i>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ</i> | 11:20-11:25 |
| Хурлыг хаах<br><i>Хурлын дарга Б.Амарсайхан</i>                                                                                                                | 11:25-11:30 |

Хурлын үргэлжлэх хугацаа: 1 цаг 30 минут

*Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.*



# 1. КОМПАНИЙГ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХЭЛБЭРЭЭР ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ТУХАЙ

## 1. Өмнөх шийдвэр, хэрэгжилтийн явц

2025 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн “Говь” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн эрх зүйн хэлбэрийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх тухай шийдвэр гаргасан.

Дээрх шийдвэрийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2025 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн №39 дугаар тогтоолоор Компанийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн өөрийн эзэмшлийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх (шаардах эрх)-ийг хэрэгжүүлэх ажиллагааг зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Уг ажиллагааны явцад эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт явуулж, холбогдох акт гарсан бөгөөд уг асуудалтай холбоотой захиргааны хэрэг шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд байна.

Өнөөдрийн байдлаар компанийн эрх зүйн хэлбэрийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх ажиллагаа хуульд заасан журмын дагуу эцэслэн хэрэгжээгүй бөгөөд компани Улсын бүртгэлд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр бүртгэлтэй хэвээр байна.

Мөн энэ хугацаанд компанийн хувьцаа Монголын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдаж байгаа бөгөөд хувьцаа эзэмшигчид өөрсдийн эзэмшиж буй хувьцааг хууль тогтоомжид заасан журмын дагуу чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэвийн хэрэгжүүлсэн ирсэн болно.

## 2. ТУЗ-өөс хийсэн стратегийн дахин үнэлгээ

Компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх тухай шийдвэр гарснаас хойш ТУЗ-өөс компанийн урт хугацааны хөгжлийн стратеги, хөрөнгийн зах зээлийн орчин, санхүүжилтийн боломж, компанийн засаглалын бодлого болон нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт үзүүлэх нөлөөллийг дахин авч үзэж, дараах дүгнэлтүүдэд хүрэв.

### 2.1 Компанийн урт хугацааны хөгжлийн стратеги

Компанийн өсөлт, өрсөлдөх чадвар болон ирээдүйн хөрөнгө оруулалтын боломжийг хангах үүднээс дараах хүчин зүйлс чухал ач холбогдолтой гэж үзэв. Үүнд:

- Дотоод болон олон улсын зах зээл дэх өсөлтийн боломжийг хадгалах;
- Компанийн зах зээлд эзлэх байр суурь, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх;
- Ирээдүйн хөрөнгө оруулалт, тэлэлтийн боломжийг хадгалах;
- Компанийн үнэ цэнийг урт хугацаанд нэмэгдүүлэхэд чиглэсэн стратегийн уян хатан байдлыг хангах.

### 2.2 Компанийн засаглал, ил тод байдал

Нээлттэй хувьцаат компанийн засаглалын тогтолцоо нь компанийн тогтвортой хөгжил, хөрөнгө оруулагчдын итгэл болон компанийн нэр хүндийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэв. Үүнд:

- Мэдээллийн ил тод байдал, тайлагналын тогтолцоог хэрэгжүүлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангах;
- ТУЗ-ийн хараат бус хяналтын тогтолцоог бэхжүүлэх;
- ESG болон компанийн засаглалын олон улсын сайн туршлагад нийцсэн бодлого, тогтолцоог бэхжүүлэх.

### 2.3 Олон улсын санхүүжилтийн боломж

Компанийн нээлттэй, ил тод засаглал нь олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах, урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэрийг өргөжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой гэж үзэв. Үүнд:

- Олон улсын банк, хөгжлийн санхүүгийн байгууллагуудаас урт хугацааны санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх;
- Санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх;
- Компанийн хөрөнгө татах чадвар, санхүүгийн уян хатан байдлыг дэмжих;
- Урт хугацааны хөрөнгө оруулагчдын итгэлийг бэхжүүлэх.



## 2.4 Хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг

Нийт хувьцаа эзэмшигчдийн урт хугацааны эрх ашиг болон компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилтыг харгалзан үзэв. Үүнд:

- Хөрөнгийн зах зээл дээр хувьцааг чөлөөтэй арилжаалах боломжийг хадгалах;
- Хувьцаа эзэмшигчдийн өмчийн болон мэдээлэл авах эрхийг хангах;
- Дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоо, сонирхлыг дэмжих;
- Компанийн урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэх.

## 3. Дүгнэлт

ТУЗ-өөс компанийн урт хугацааны хөгжлийн стратеги, хөрөнгийн зах зээлийн орчин, олон улсын санхүүжилтийн боломж, хөрөнгө оруулагчдын эрх ашиг болон компанийн урт хугацааны үнэ цэнийг цогцоор нь дахин авч үзсэний үндсэн дээр компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр үргэлжлүүлэх нь компанийн тогтвортой хөгжил, өрсөлдөх чадвар болон нийт хувьцаа эзэмшигчдийн урт хугацааны эрх ашигт илүү нийцнэ гэж дүгнэн, компанийн эрх зүйн хэлбэрийг нээлттэй хувьцаат компани хэвээр үргэлжлүүлэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.



## 2. ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 2026 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн №03 дугаар тогтоолоор 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх нэр дэвшигчдийг шийдвэрлэсэн.



### "ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай Г

Говь ХК (цаашид "Компани" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн гишүүнд нэр дэвшигчдийг хэлэлцэн, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5.2, 81.5.3 дахь заалт, Компанийн "ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам", Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журмыг тус тус үндэслэн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны хурлаас **ТОГТООХ нь:**

1. ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Жаргалмаа өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөнтэй тул ТУЗ-ийн 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн №19 дүгээр тогтоолоор Р.Саранцэцэгийг дараагийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүнийг сонгох хүртэл хугацаанд хараат бус гишүүнээр түр томилсныг дурдсугай.
2. Компанийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд ТУЗ-ийн гишүүнээр дараах нэр дэвшигчдийг нэр дэвшүүлсүгэй.


#### ТУЗ-ийн хараат бус гишүүнд:

1. Дамба овогтой ГЭРЭЛМАА
2. Дамбийжав овогтой ХҮРЭЛБААТАР нарыг улируулан нэр дэвшүүлэх
3. Равжин овогтой САРАНЦЭЦЭГ-ийг шинээр нэр дэвшүүлэх

#### ТУЗ-ийн ердийн гишүүнд:

1. Баатарсайхан овогтой АМАРСАЙХАН
  2. Цагаач овогтой БААТАРСАЙХАН
  3. Цогтгэрэл овогтой ОРГИЛБОЛД
  4. Дашдаваа овогтой ХУЛАН
  5. Батжаргал овогтой ОРГИЛ
  6. Баатарсүрэн овогтой ЦЭЦЭНМ нарыг улируулан нэр дэвшүүлэх
3. Энэхүү тогтоолыг Нэр дэвшүүлэх хорооны гишүүд санал нэгтгэйгээр баталсугай.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДАРГА



Д.ГЭРЭЛМАА

"Говь" ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17062, Монгол улс  
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, И-мэйл: [info@gobi.mn](mailto:info@gobi.mn), Вэб сайт: [www.gobi.mn](http://www.gobi.mn)

## ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА



**Д.ГЭРЭЛМАА**

### МЭРГЭЖИЛ

Эдийн засагч

### БОЛОВСРОЛ

1982-1988

ЗХУ, Москва хотын Цахилгаан Холбооны Дээд Сургууль, Холбооны инженер эдийн засагч, бакалавр

2000-2003

МУ-ын ЗГ-ийн хэрэгжүүлэгч агентлаг "Удирдлагын академи", удирдахуйн ухааны доктор

### ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1988-1992

Радио Телевизийн Техникийн Төв, эдийн засагч

1992-1994

Эдийн Засгийн Хөгжлийн Коллеж, Бизнес удирдлагын тэнхим, Багш

1994-2003

Эдийн Засгийн Хөгжлийн Коллеж, Бизнес удирдлагын тэнхим, Тэнхимийн эрхлэгч

2003-2006

Монгол Улсаас НҮБ-д суух Байнгын төлөөлөгчийн газар, Швейцарийн Холбооны улс дахь ЭСЯ, Нягтлан бодогч

2006-2009

СЭЗИС, Сургалт Эрдэм Шинжилгээ эрхэлсэн дэд захирал

2009-2015

СЭЗИС, Сургалт эрхэлсэн дэд захирал

2015-2022

СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор

2022-2024

СЭЗИС, Ахисан Түвшний сургуулийн профессор

2024 оноос

СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор

### 2013 оноос

Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн

### ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

Хувьцаа эзэмшдэггүй.



**Д.ХҮРЭЛБААТАР**

### МЭРГЭЖИЛ

Нягтлан бодогч, Эдийн засагч, Санхүүч

### БОЛОВСРОЛ

1979-1981

Монгол улс, Худалдааны Техникум, Нягтлан бодогч, бакалавр

1985-1989

ОХУ, Байгалийн Улсын Их сургууль (Иркутск хотын УАААДС), Эдийн засагч, санхүүч магистр

### ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1981-1984

Улсын банк, Улсын байцаагч аудитор

1990-2005

Худалдаа Хөгжлийн Банк, Харилцагчийн үйлчилгээний газрын захирал

2005-2007

Монгол шуудан банк, Дэд захирал

2008-2016

Говь ХК, ТУЗ-ийн гишүүн

2007-2020

Худалдаа Хөгжлийн Банк, Гүйцэтгэх захирлын орлогч

2020-2022

Худалдаа Хөгжлийн Банк, ТУЗ-ийн ажлын албаны дарга

### 2022 оноос

Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн

### ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

4,800 ширхэг (0.0006%)



**Р.САРАНЦЭЦЭГ**

#### **МЭРГЭЖИЛ**

Эдийн засагч

#### **БОЛОВСРОЛ**

1986-1991

ОХУ, Санкт-Петербург хот, Санхүү эдийн засгийн их сургууль, Макро эдийн засгийн төлөвлөлт эдийн засагч, бакалавр

2003-2004

АНУ, Нью-Йорк хот, Колумбын Их Сургууль, Төрийн удирдлага, магистр

#### **ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

1998-2005

Монголбанк, Мөнгөний бодлого, судалгааны газар, Мөнгөний бодлогын хэлтэс, Ахлах эдийн засагч, Эдийн засагч

2005-2016

Монголбанк, Мөнгөний бодлого, судалгааны газар, Мөнгөний бодлогын хэлтэс, Хэлтсийн захирал

2016-2024

Монголбанк, Мөнгөн тэмдэгтийн газар, Газрын захирал

**2026 оны 5-р сараас**

**Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн**

#### **ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**

Хувьцаа эзэмшдэггүй.

## **ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА**



**Б.АМАРСАЙХАН**

#### **МЭРГЭЖИЛ**

Бизнесийн удирдлага ба энтерпренершип

#### **БОЛОВСРОЛ**

2016 - 2019

Их Британи улс, Westminster Их Сургууль, Бизнесийн удирдлага ба энтерпренершип, бакалавр

#### **ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2019-2023

Говь Кашмер Европ ХХК, Гүйцэтгэх захирал

2022-2024

Говь ХК, Стратеги, өсөлт хөгжил хариуцсан захирал

2022 оноос

Таван Богд Холдингс ХХК, Стратеги, бизнес хөгжил хариуцсан захирал

2022 оноос

Говь Кашмер Их Британи ХХК, Гүйцэтгэх захирал

2023 оноос

Говь Кашмер Казахстан ХХК, Говь Кашмер Америк ХХК, Говь Кашмер Өвөр Монгол ХХК, Гүйцэтгэх захирал

2024 оноос

Говь ХК, Гоёо ХХК, Гүйцэтгэх захирал, Говь Австрали салбарын захирал

**2023 оноос**

**Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

#### **ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**

Хувь хүн: 1,000 ширхэг (0.0001%)

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 682,676,598 ширхэг (87.51%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 277,182 ширхэг (0.04%)



Ц.БААТАРСАЙХАН

#### МЭРГЭЖИЛ

Инженер

#### БОЛОВСРОЛ

1984-1988

Монгол улс, Политехникийн Их Сургууль, Холбооны инженер, бакалавр

1989-1993

Япон улс, Токио хотын Цахилгаан Холбоо, Электроникийн Их Сургууль, Электроникийн инженер, бакалавр

#### ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1993-1997

Япон Монголын хамтарсан Алтай ХХК, Гүйцэтгэх захирал

1999-2000

Жуулчин ХХК, Ерөнхий захирал

2000-2001

Палас зочид буудал, Гүйцэтгэх захирал

2001-2003

МИАТ ТӨХК, Дэд ерөнхийлөгч

2008-2024

Говь ХК, Гүйцэтгэх захирал

1997 оноос

Таван Богд Холдингс ХХК, Ерөнхий захирал

2003 оноос

Таван Богд Групп, Ерөнхийлөгч

2009 оноос

Хаан Банк ХК, ТУЗ-ийн гишүүн

**2007 оноос**

**Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

#### ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

Хувь хүн: 50,000 ширхэг (0.006%)

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 682,676,598 ширхэг (87.51%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 277,182 ширхэг (0.04%)



Б.ОРГИЛ

#### МЭРГЭЖИЛ

Санхүүгийн удирдлага

#### БОЛОВСРОЛ

2006-2011

Бүгд Найрамдах Турк Улс, Bogazici University, Олон улсын худалдаа, санхүү, бакалавр

2012-2015

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Санхүүгийн менежмент магистр  
CFA Level 2 тэнцсэн

#### ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2011-2012

СББ Трейд ХХК, Мэргэжилтэн

2012-2013

Эрдэнэс Оюу Толгой ХХК, Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн

2013-2018

Монголын Төмөр Зам ТӨХК, Эдийн засгийн албаны менежер

2018-2022

Иргэний Нисэхийн Ерөнхий Газар, Эдийн засгийн зохицуулалтын тасгийн дарга

2022-2025

Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК, Зөвлөх

2025 оноос

Таван Богд Холдингс ХХК, Санхүү удирдлага хариуцсан захирал

**2025 оноос**

**Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

#### ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

Хувь хүн: Хувьцаа эзэмшдэггүй.

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 682,676,598 ширхэг (87.51%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 277,182 ширхэг (0.04%)



Ц.ОРГИЛБОЛД

#### МЭРГЭЖИЛ

Олон улсын харилцаа

#### БОЛОВСРОЛ

2011-2014

Япон улс, Temple Их Сургууль, Олон улсын харилцаа, бакалавр

#### ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2014

Эдийн засгийн хөгжлийн яам, Чөлөөт бүс хариуцсан мэргэжилтэн

2016

Таван Богд Холдингс ХХК, Бизнес хөгжлийн менежер

2016-2017

Жуулчин Дютри Фрий ХК, Гүйцэтгэх захирал

2017-2019

Гоёо ХХК, Гүйцэтгэх захирал

2019-2021

Говь ХК, Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал

2021-2022

Саппорт Сервисес Монголиа ХХК, Дэд захирал

2022-2023

Говь ХК, Тэргүүн дэд захирал /Дизайн, үйлдвэрлэл, дэмжих/

2023-2025

Говь ХК, Тэргүүн дэд захирал /Гадаад, экспортын борлуулалт/

2023 оноос

Говь Кашмер Европ ХХК, Гүйцэтгэх захирал

**2023 оноос**

**Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

#### ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

Хувь хүн: Хувьцаа эзэмшдэггүй.

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 682,676,598 ширхэг (87.51%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 277,182 ширхэг (0.04%)



Д.ХУЛАН

#### МЭРГЭЖИЛ

Олон улсын банк санхүү

#### БОЛОВСРОЛ

1985-1990

Орос улс, Москвагийн Санхүүгийн Дээд Сургууль, Олон улсын банк санхүү, бакалавр

#### ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1990-1992

Монгол Улсын Сангийн Яам, Эдийн засгийн гадаад харилцааны хэлтэс, Эдийн засагч

1993-1997

Говь ХК, Токио дахь салбар, Төлөөлөгч, худалдааны менежер

1997-2000

Таван Богд Холдингс ХХК, Дэд захирал

2000-2002

Худалдаа Хөгжлийн Банк, Дэд захирал

2003-2021

Таван Богд Групп, Тэргүүн дэд ерөнхийлөгч

2003-2021

Хаан Банк ХК, ТУЗ-ийн гишүүн

2009 оноос

Люксембург улсын Монгол дахь өргөмжит консул

2021 оноос

Хаан Банк ХК, ТУЗ-ийн дэд дарга

2021 оноос

Таван Богд Групп, ТУЗ-ийн дарга

**2007 оноос**

**Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

#### ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

Хувь хүн: 13,352,531 ширхэг (1.71%)

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 682,676,598 ширхэг (87.51%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 277,182 ширхэг (0.04%)





**Б.ЦЭЭНЯМ**

#### **МЭРГЭЖИЛ**

Маркетингийн менежмент

#### **БОЛОВСРОЛ**

2014-2018

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Маркетингийн менежмент, бакалавр  
2022-2023

АНУ, Lindenwood Их Сургууль, Бизнесийн удирдлага, магистр

#### **ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2018-2021

Таван Богд Холдингс ХХК, Маркетингийн газар, Судалгааны менежер  
2023-2025

АНУ, Anand Resource компани, Ерөнхий менежер

2025-2025

Таван Богд Холдингс ХХК, Дотоод аудит хариуцсан дэд захирал  
2025 оны 12-р сараас

Ар И Ди Эженси ХХК, Гүйцэтгэх захирал

#### **2024 оноос**

**Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

#### **ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**

Хувь хүн: Хувьцаа эзэмшдэггүй.

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:

Таван Богд Холдингс ХХК 682,676,598 ширхэг (87.51%)

Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)

Таван Богд Капитал ҮЦК ХХК 277,182 ширхэг (0.04%)



# ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСӨЛ

Төсөл

## ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 9-р сарын 25-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

### *Компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр үргэлжлүүлэх тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4, 62.1.15, “Говь” ХК (“Компани”)-ийн дүрмийн 6.1 дүгээр зүйлийн 6.1.9.4, 6.1.9.13 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Компанийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын стратеги, хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол болон компанийн хэлбэр өөрчлөх ажиллагаа дуусгавар болоогүй нөхцөл байдлыг харгалзан 2026 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын санал хураасан дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. 2025 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн “Говь” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын “Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай” №01 дүгээр тогтоол, “Компанийн хэлбэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай” №02 дугаар тогтоолыг тус тус цуцалсугай.
2. “Говь” ХК-ийн эрх зүйн хэлбэрийг нээлттэй хувьцаат компани хэвээр хадгалж, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэлтэй нээлтэй хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлсүгэй.
3. Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасан хувьцаа эзэмшигчийн шаардах эрх нь 2025 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн шийдвэрийн дагуу үүссэн боловч уг эрхийг хэрэгжүүлэхээр Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан шаардлага гаргасан, хувьцаагаа компанид эргүүлэн худалдсан хувьцаа эзэмшигч байхгүй болохыг тэмдэглэсүгэй.
4. “Говь” ХК-ийн 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №02 дугаар тогтоолын Хавсралт 2-оор батлагдсан Компанийн дүрмийг хүчин төгөлдөр хэвээр мөрдсүгэй.
5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан компанийн хэлбэр өөрчлөх, хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасуулахтай холбоотой өмнө гаргасан хүсэлт, ажиллагааг дуусгавар болгох, шаардлагатай мэдэгдэл, хүсэлт болон баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК болон бусад холбогдох байгууллагад хууль, журамд заасны дагуу хүргүүлэх, тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захиралд даалгасугай.

### ХУРЛЫН ДАРГА

**ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 9-р сарын 25-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4, "Говь" ХК ("Компани")-ийн дүрмийн 6.1 дүгээр зүйлийн 6.1.9.8, 6.2.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2026 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын санал хураасан дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**


1. "Говь" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.
2. "Говь" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 (гурван) жилийн хугацаагаар сонгон томилсугай.
  - 2.1. Хараат бус гишүүд:  
Дамба овогтой ГЭРЭЛМАА  
Дамбийжав овогтой ХҮРЭЛБААТАР  
Равжин овогтой САРАНЦЭЦЭГ
  - 2.2. Ердийн гишүүд:  
Баатарсайхан овогтой АМАРСАЙХАН  
Цагаач овогтой БААТАРСАЙХАН  
Батжаргал овогтой ОРГИЛ  
Цогтгэрэл овогтой ОРГИЛБОЛД  
Дашдаваа овогтой ХУЛАН  
Баатарсүрэн овогтой ЦЭЭНЯМ
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдэд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм компанийн засаглалтай холбоотой дүрэм журмыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

**ХУРЛЫН ДАРГА**



# ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2026 оны 08-р сарын 14-ны өдрийн хурлын  
27-р тогтоолын 7-р хавсралт




## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС

|                 |                                                               |               |
|-----------------|---------------------------------------------------------------|---------------|
| Комиссын дарга  | "БиДиСек ҮЦК" ХХК, Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал        | Б.Онон        |
| Комиссын гишүүд | "БиДиСек ҮЦК" ХХК, Бизнес хөгжил, судалгааны албаны удирдлага | Э.Пүрэвжаргал |
|                 | "БиДиСек ҮЦК" ХХК, Харилцагчийн албаны мэргэжилтэн            | Г.Анхбаяр     |



# САНАЛ АВАХ ХУУДАСНЫ ЗАГВАР

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2026 оны 08-р сарын 14-ны өдрийн хурлын  
27-р тогтоолын 3-1-р хавсралт



## “ГОВЬ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС №1

Хурлын өдөр: 2026 оны 9-р сарын 25-ны өдөр, Баасан гараг  
Эхлэх цаг: 10:00 цаг  
Хурал зохион байгуулах хэлбэр: AGM систем (www.agm.mn)-ийг ашиглан **цахим хэлбэрээр**

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ:

|                                                                           |  |
|---------------------------------------------------------------------------|--|
| Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:                                            |  |
| Иргэний бүртгэлийн дугаар:<br>/Хуулийн этгээдийн хувьд регистрийн дугаар/ |  |
| Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо:                                         |  |
| Утасны дугаар:                                                            |  |
| И-мэйл хаяг:                                                              |  |

### САНАЛ ХУРААХ АРГА: ЭНГИЙН АРГА

| № | Шийдвэр гаргаж, батлах асуудал                                                     | Хурлаас гарах шийдвэр                                              | Зөвшөөрсөн               | Татгалзсан               | Түдгэлзсэн               |
|---|------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------|--------------------------|--------------------------|--------------------------|
| 1 | Компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр үргэлжлүүлэх тухай хэлэлцэн батлах | Компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр үргэлжлүүлэх тухай | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: ..... / .....

Санал өгсөн огноо: 2026 оны ... -р сарын ... -ны өдөр

Урьдчилсан санал өгсөн тохиолдолд саналын хуудас хүлээн авсан (сонгох) :

☐ Үнэт цаасны компани ..... ☐ Говь ХК

Хүлээж авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал: ..... / .....



**Санал өгөх заавар:**

- Та саналын хуудсыг бөглөхдөө хувилбарын зөвхөн нэгийг сонгож ( ✓ ) гэж тэмдэглэнэ үү.
- Засварласан, балласан, ( ✓ )-ээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн, нэгээс олон санал бөглөсөн эсхүл аль нэг саналыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.
- Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт, саналыг арын нүүрэнд бичих боломжтой.

**Санамж:**

- **Урьдчилан санал өгөх:** Саналын хуудсыг бөглөж дараах арга хэлбэрээр **2026 оны 9-р сарын 22-ны өдрийн 17:00 цаг хүртэл** иргэний үнэмлэх (хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ)-ний хуулбарын хамт ирүүлнэ үү:
  - Өөрийн харилцдаг үнэт цаасны компани эсвэл хурлын тооллогын комиссоор ажиллаж буй БиДиСек ҮЦК ХХК (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, Утас: 7555-1919)-аар дамжуулан өгөх;
  - Говь ХК-ийн оффисын төв байранд биечлэн ирж өгөх, эсвэл шуудангаар илгээх (Монгол Улс, УБ-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК);
  - Цахимаар ирүүлэх ([boardsecretary@gobicashmere.com](mailto:boardsecretary@gobicashmere.com)).
- **Жич: Та урьдчилан санал өгсөн тохиолдолд дахин санал өгөх эрхгүй болно.**
- **Төлөөлүүлэн санал өгөх:** Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгөн, **нотариатаар баталгаажуулсан байх** шаардлагатай.

---

**Тооллогын комисс бөглөх хэсэг:**

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: ☐ Тийм ☐ Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: ..... / .....

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: .....  
.....



Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2026 оны 08-р сарын 14-ны өдрийн хурлын  
27-р тогтоолын 3-2-р хавсралт



**“ГОВЬ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН  
САНАЛ АВАХ ХУУДАС №2**

Хурлын өдөр: 2026 оны 9-р сарын 25-ны өдөр, Баасан гараг

Эхлэх цаг: 10:00 цаг

Хурал зохион байгуулах хэлбэр: AGM систем (www.agm.mn)-ийг ашиглан **цахим хэлбэрээр**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ:**

|                                                                                |  |
|--------------------------------------------------------------------------------|--|
| Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:                                                 |  |
| Иргэний бүртгэлийн дугаар:<br>/Хуулийн этгээдийн хувьд регистрийн дугаар/      |  |
| Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо:                                              |  |
| Кумулятив аргаар өгөх саналын тоо:<br>(эзэмшиж буй хувьцааны тоог 9-өөр үржих) |  |
| Утасны дугаар:                                                                 |  |
| И-мэйл хаяг:                                                                   |  |

**САНАЛ ХУРААХ АРГА: КУМУЛЯТИВ АРГА**

| № | Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс | Нэр дэвшигчдэд өгөх кумулятив саналын тоо |
|---|--------------------------------------------------------------------|-------------------------------------------|
| 1 | Дамба овогтой ГЭРЭЛМАА                                             |                                           |
| 2 | Дамбийжав овогтой ХҮРЭЛБААТАР                                      |                                           |
| 3 | Равжин овогтой САРАНЦЭЦЭГ                                          |                                           |

| № | Төлөөлөн удирдах зөвлөлийн өрдийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс | Нэр дэвшигчдэд өгөх кумулятив саналын тоо |
|---|----------------------------------------------------------------|-------------------------------------------|
| 1 | Баатарсайхан овогтой АМАРСАЙХАН                                |                                           |
| 2 | Цагаач овогтой БААТАРСАЙХАН                                    |                                           |
| 3 | Батжаргал овогтой ОРГИЛ                                        |                                           |
| 4 | Цогтгэрэл овогтой ОРГИЛБОЛД                                    |                                           |
| 5 | Дашдаваа овогтой ХУЛАН                                         |                                           |
| 6 | Баатарсүрэн овогтой ЦЭЭНЯМ                                     |                                           |

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал: ..... / .....

Санал өгсөн огноо: 2026 оны ... -р сарын ... -ны өдөр

Урьдчилсан санал өгсөн тохиолдолд саналын хуудас хүлээн авсан (сонгох) :

☐ Үнэт цаасны компани ..... ☐ Говь ХК

Хүлээж авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал: ..... / .....





**Кумулятив аргаар санал өгөх заавар:**

- Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн 1 хувьцаа нь 9 кумулятив саналын эрхтэй байна.
- Хувьцаа эзэмшигч нь нийт кумулятив саналын эрхээ нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх боломжтой.

*Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нь 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг бол кумулятив аргаар санал өгөх нийт 900 саналын эрхтэй /100 хувьцаа х 9 гишүүн = 900 санал/ болно. Хувьцаа эзэмшигч А нь 900 саналын эрхээ бүгдийг нь ТУЗ-ийн ердийн ба хараат бус гишүүнээс үл хамааран өөрийн сонгосон аль нэг нэр дэвшигчид өгч болно. Эсвэл хэд хэдэн нэр дэвшигчдэд тус тус дурын харьцаагаар хуваарилан өгч болно.*

- Таны өгсөн саналын нийлбэр дүн нь кумулятив аргаар өгөх нийт саналын тооноос хэтэрч болохгүй. Хэтэрсэн тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцно.
- Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт, саналыг арын нүүрэнд бичих боломжтой.

**Санамж:**

- **Урьдчилан санал өгөх:** Саналын хуудсыг бөглөж дараах арга хэлбэрээр **2026 оны 9-р сарын 22-ны өдрийн 17:00 цаг хүртэл** иргэний үнэмлэх (хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ)-ний хуулбарын хамт ирүүлнэ үү:
  - Өөрийн харилцдаг үнэт цаасны компани эсвэл хурлын тооллогын комиссоор ажиллаж буй БидиСек ҮЦК ХХК (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, Утас: 7555-1919)-аар дамжуулан өгөх;
  - Говь ХК-ийн оффисын төв байранд биечлэн ирж өгөх, эсвэл шуудангаар илгээх (Монгол Улс, УБ-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК);
  - Цахимаар ирүүлэх ([boardsecretary@gobicashmere.com](mailto:boardsecretary@gobicashmere.com)).
- **Жич:** Та урьдчилан санал өгсөн тохиолдолд дахин санал өгөх эрхгүй болно.
- **Төлөөлүүлэн санал өгөх:** Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгөн, **нотариатаар баталгаажуулсан байх** шаардлагатай.

---

**Тооллогын комисс бөглөх хэсэг:**

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: ☐ Тийм ☐ Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: ..... / ..... /

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: .....

.....

# ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ХУРАЛД ОРОЛЦОХ ЗААВАР

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг AGM системийг ашиглан **цахим хэлбэрээр** зохион байгуулна.

## 1. Хуралд нэвтрэх

Хувьцаа эзэмшигч нь **www.agm.mn** цахим хаягаар нэвтрч, **“Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал”** хэсгийг сонгон нэвтрэх хуудас руу шилжинэ.

- Монгол Улсын иргэн бол **E-Mongolia** системээр нэвтрэх боломжтой.
- Хуулийн этгээд, гадаад улсын иргэн, насанд хүрээгүй хувьцаа эзэмшигч бол **“БҮРТГҮҮЛЭХ”** цэсээр бүртгэл үүсгэн, бүртгүүлсэн мэдээллээрээ нэвтрэнэ.

## 2. Хуралд оролцох

AGM системд нэвтэрсний дараа хувьцаа эзэмшигч нь хуралд цахимаар оролцож, хуралтай холбоотой мэдээлэлтэй танилцах боломжтой.

## 3. Санал өгөх

Хурлаар хэлэлцэх асуудал бүрээр AGM системээр дамжуулан цахим санал өгөх боломжтой.

## 4. Асуулт илгээх

Хуралтай холбоотой асуулт, санал хүсэлтийг AGM системээр дамжуулан илгээх боломжтой.

## 5. Дэлгэрэнгүй заавар

AGM системд нэвтрэх, хуралд оролцох, санал өгөх болон асуулт илгээхтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг **www.agm.mn** цахим хаяг дахь **“AGM системийг ашиглах хувьцаа эзэмшигчдийн гарын авлага”** хэсгээс авна уу.

## 6. Холбоо барих

AGM системтэй холбоотой техникийн асуудлаар **7555-1919** дугаарын утсаар холбогдоно уу.



"ГОВЬ" ХК,  
ҮЙЛДВЭРИЙН ГУДАМЖ, 3-Р ХОРОО, ХАН-УУЛ ДҮҮРЭГ,  
УЛААНБААТАР-17062, МОНГОЛ УЛС, Ш/Х 36/434

УТАС: +976 7013-9977, ФАКС: +976 7014-3081  
И-МЭЙЛ: [INFO@GOBI.MN](mailto:INFO@GOBI.MN)